



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№161 /375/

2022.09.12

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМД ХООРОНДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ БОЛЖ БАЙНА



Монгол Улсын Батлан хамгаалах яам, Австралийн Холбооны Улсын Батлан хамгаалах яам хоорондын 7 дахь зөвлөлдөх уулзалт 9 дүгээр сарын 9-13-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байна. Өнөөдөр зөвлөлдөх уулзалтыг нээж Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг болон Австралийн Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Кэйти Смит нар үг хэлэв.

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг уулзалтыг нээж хэлсэн үгэндээ Их Британи Умард Ирландын

Нэгдсэн Хаант Улсын Цог жавхлантай Эрхэм Хатан хаан Хоёрдугаар Элизабет таалал төгссөнд Хааны гэр бүлд болон Австралийн Холбооны Улсын нийт иргэдэд Монгол Улсын Батлан хамгаалах яамны зүгээс болон хувиасаа гүн эмгэнэл илэрхийлэв.

Австралийн Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Кэйти Смит улсад нь тохиосон уй гашууг хуваалцсанд хариу талархал илэрхийлээд өнөөдрийн зөвлөлдөх уулзалт хоёр орны Батлан хамгаалах салбарын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиглэлээр олон санал солилцсон уулзалт болно гэдгийг онцлолоо.

Холбооны Улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны нэг чухал арга хэмжээ бол хоёр орны батлан хамгаалах аюулгүй байдлын асуудлаар Батлан хамгаалах яамд хоорондын зөвлөлдөх уулзалт байдаг. Тус уулзалтаар талууд цар тахлын улмаас хойшлогдоод байсан зарим төлөвлөгөөт ажлуудыг сэргээхээс гадна хамтын ажиллагааны шинэ боломжийг эрэлхийлсэн үр дүнтэй уулзалт болно гэдгийг харилцан тэмдэглэв. Уулзалтад Австралийн Холбооны Улсын БХЯ-ны Хойд Азийн гадаад бодлогын газрын дарга доктор Рачел Аллен, Австралийн Холбооны Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн

бичгийн дарга Жак Түминелло, Сөүлээс Монголыг хавсран суугаа Австралийн цэргийн атташе, Тэнгисийн цэргийн ахмад Крис Смит болон Монгол Улсын Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн, хурандаа С.Амарсайхан, мэргэжилтэн, хошууч Ц.Даваадорж, ЗХЖШ-ын Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Ж.Молорболд, Сөүл хотоос Австралийн Холбооны Улсыг хавсран суугаа Монгол Улсын Батлан хамгаалахын атташе, дэд хурандаа Э.Түшигнаролцсон юм.

“АЛСЫН ХАРАА-2050” СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ ӨНДӨРЛӨВ



Удирдлагын академи, Батлан хамгаалах яам хамтран “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг сурталчлах сургалтыг 9 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний алба хаагчдад явууллаа. Сургалтад Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрийн цэргийн командлалын томилогдсон алба хаагчдад Удирдлагын академийн багш нар Монгол Улсын ирэх 30 жилийн хөгжлийг боловсруулах бодит шаардлага хэрхэн тулгарсан талаар танилцуулж, хүний хөгжил, эдийн засаг, засаглал, шинэ сэргэлтийн бодлого зэргийг онол болон дадлага буюу багийн ажиллагаагаар дасгал боловсруулж, нэгдсэн ойлголтод хүргэв.

Монгол Улсын цаашдын ирээдүйн макро эдийн засгийн бодлого нь урт хугацаанд тогтвортой, мөчлөг сөрсөн, өрийн дарамт болон зардлын өсөлтийн нарийвчлан тооцсон аргачлалаар дунд хугацаанд эдийн засгийг тогтворжуулж, улмаар урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангасан өөрөө өөрийгөө тэтгэсэн, гадаад зах зээлийн сөрөг өөрчлөлтөөс дархлагдсан байх шаардлагатай бөгөөд эдийн засгийн өсөлт хүний хөгжил, дундаж орлоготой иргэдийг тэтгэх цогц бодлого уруу

илүүтэй чиглэх бодит шаардлага байгааг сургагч багш нар онцолж байсан юм.

Сургалтын төгсгөлд идэвх оролцоо, санаачилга, багийн бүтээлч ажиллагаа, эерэг хандлагаар шилдэг баг, шилдэг оролцогчдыг тодруулж, шагнал гардуулав. Зохион байгуулагч талаас Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний алба хаагчдыг сургалтад өгч буй ач холбогдол, идэвх оролцоо асар өндөр байсныг дурдаад төрийн алба хаагч болон хувь иргэн талаасаа үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын төлөө өгөгдсөн даалгавар бүрт нэгдэж байсныг нэмж тодотгож байв.

Сургагч багш нар болон оролцогчдын өгсөн үнэлгээгээр шилдэг багаар дэд хурандаа А.Батсүхээр ахлуулсан ЗХЖШ-ын баг, шилдэг оролцогчдоор хурандаа Г.Энхболд (БХЯ), дэд хурандаа А.Батсүх (ЗХЖШ), хошууч Д.Мөнхбат (БХЯ), хошууч Б.Хүрэлсүх (Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл), ахмад М.Саруулгэрэл (Барилга-инженерийн цэргийн удирдах газар), ахмад Д.Болормаа (ХЗЦК) нар шагларч, бестселлер номуудаар шагнагдав. Сургалт өдгөө үргэлжлэн цахимаар явагдаж байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌧️ 13


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	🌧️ 21

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.222.00	3.248.0
EUR 🇪🇺	3.140.0	3.405.0
CNY 🇨🇳	462.00	481.00
RUB 🇷🇺	45.80	61.10
JPY 🇯🇵	22.31	23.39
KRW 🇰🇷	2.21	2.45

ЗУРХАЙ



2022.09.12 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 17

НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ШАР ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Өнгө зүс доройтно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.25-19.12

БАРИЛДЛАГА:

Рашаан

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Сэрэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 582,373,933

Эдгэрсэн

Нийт: 552,651,454

Нас барсан

Нийт: 6,419,951

ХАНГАЙН БҮСЭД ТОМИЛГООТ НЭГЖИЙН ХЭЭРИЙН СУРГАЛТ БОЛОВ



Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага, сургалт Өвөрхангай аймгийн Хужирт сумын "Цагаан залаа" хүүхдийн зуслангийн районд 3 хоногийн хугацаанд болж өндөрлөлөө.

Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн дагуу энэ жил анх удаа Өвөрхангай аймгийн хангайн бүс буюу Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Зүүнбаян-Улаан, Уянга сумын томилгоот нэгжүүдийг үүсэж болзошгүй цагийн байдалд өөрийн бүс, орон нутгаа хэрхэн хамгаалах, шаардлагатай үед эзэмшвэл зохих ур чадварт сургах зорилгоор хээрийн дадлага, сургалтад хамрууллаа.

Дадлага, сургалтын хаалтын үйл ажиллагаанд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Өвөрхангай аймгийн Засаг дарга А.Ишдорж, Батлан хамгаалахын сайдын зөвлөх, бэлтгэл дэслэгч генерал Ц.Дашзэвэг, БХЯ-ны Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн цэргийн дайчилгааны хэлтсийн дарга, хурандаа Х.Баньд, Өвөрхангай, Төв аймгийн Цэргийн штабын дарга нар бусад албаны хүмүүс оролцлоо.

Батлан хамгаалахын сайд Г.САЙХАНБАЯР:

"Дэлхийн улс орнуудын цэрэг, улс төрийн байдал эмзэг мэдрэмтгий байгаа энэ үед өргөн уудам газар нутагтай, хүн ам цөөтэй манайх шиг улс орны хувьд Орон нутгийн нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэх нь оновчтой, чухал алхам юм. Үүнийг хэрэгжүүлэхэд ард иргэд та бүхний эх орноо гэсэн сэтгэл, хамтын ажиллагаа чухал байх болно. Манай улс Батлан хамгаалахын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2018 онд Улсын Их Хурлаар Орон нутгийн хамгаалалтын тухай анхдагч хуулийг батлуулсан нь орон нутгаа хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, түүний бэлтгэлийг хангах, хамгаалах, төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, ард иргэдийн хүлээх үүргийг зохицуулсан ихээхэн ач холбогдолтой зүйл болсон. Сургалтын явцаас харахад богино хугацаанд томилгоот иргэд маань гүйцэтгэх үүргээ хэрхэн суралцсаныг харлаа. Бид бүхний



цаасан дээр төлөвлөсөн зүйл бодитоор биелж ажил хэрэг болсныг харах сайхан байна. Монгол хүн бүрийн сэтгэл зүрхэнд эх орноо хайрлах, халуун сэтгэл нь дүрэлзэн байдгийг мэдрүүлсэн сургалт болж өндөрлөлөө. Хамтран ажилласан Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгийн Газар, Цэргийн штаб, сургалтад хамрагдсан иргэд та бүхэнд чинь сэтгэлтийн талархал илэрхийлье" гэв.

Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгийн Газрын Цэргийн штабын дарга хурандаа Н.ДЭЛГЭРСАЙХАН:

"2022 оны эхээр Батлан хамгаалахын сайдаас орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага, сургалтыг зохион байгуулах үүргийг Стратеги, бодлого төлөвлөлтийн газарт өгснөөр материаллаг бааз, боловсон хүчин тэрхүү байдлыг нь харгалзан үзээд манай аймагт хээрийн дадлага, сургалтыг явуулах саналыг тавьсан. Бид өнгөрөгч 6 дугаар сараас төлөвлөлтийн ажлаа гаргасан. Үүний хүрээнд уул, хад гэх мэтчлэн байгалийн бартаа саадыг харгалзан үзээд хээрийн дадлага, сургуулилт явуулах боломжтой гэж үзсэний хүрээнд

хангайн бүсийг сонгож аваад дадлага сургуулилтаа амжилттай явуулж дууслаа. Уг хээрийн дадлагийг 4 салаа, 1 тасгийн бүрэлдхүүнээр зохион байгуулсан. Галт зэвсэгтэй харилцах учраас сургалтад хамрагдаж буй хүмүүсийг сонгохдоо 70 хувь нь цэргийн алба хаасан, 30 хувь нь 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн буюу цэргийн алба хаагаагүй хүмүүс байхаар төлөвлөж 4 өдрийн хээрийн гаралтыг зохион байгуулж амжилттай дуусгалаа. Хүмүүсийн маань идэвх оролцоо маш сайн байсныг онцолъё. Эх орноо хамгаалах үүрэгтэй иргэн хүн гэдгээ тултал ухамсарлаж чадаж байгаагаас харахад энэхүү орон нутгийн хамгаалалтын дадлага, сургалт бусад аймаг, сумдад энэ мэт хэрэгжиж болохыг миний хувьд илүү томоор харж байгаа" гэлээ.

Энэхүү сургалтын үр дүнгээс хамаараад цааш, цаашдын сургалт, дадлагыг хэрхэн зохион байгуулах, эрх зүйн хувьд удирдах бүрэлдхүүний зүгээс ямар байдлаар илүү боловсронгуй болгож өгөх шаардлагатай байна вэ, гэх мэтчлэн дүгнэлтүүд гарж байгаа талаар холбогдох албаны хүмүүс хэлж байсан юм.

Сургалтын төгсгөлд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Өвөрхангай аймгийн Засаг дарга А.Ишдорж тэргүүтэй удирдлагын бүрэлдэхүүн, Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага, сургалтад амжилттай оролцсон сумын удирдлага, томилгоот нэгжийн бие бүрэлдэхүүнд баяр хүргэж, идэвх оролцоогоороо тэргүүлэн бусдаа манлайлсан хүмүүст шагнал, дурсгалын зүйлийг гардуулсан юм.



АЛДАР СПОРТ ХОРООНЫ ТАМИРЧИД БАГИЙН ДҮНГЭЭР ДЭД БАЙРТ ШАЛГАРЛАА



Монголын бүх ард түмний XV спортын их наадмын Таеквондогийн төрөлд Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны баг тамирчид тэргүүлээ.

Монголын бүх ард түмний спортын XV наадмын таеквондогийн шигшээ тэмцээн есдүгээр сарын 10-11нд Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны зааланд болж өндөрлөлөө. Тэмцээнд 20 багийн нийт 170 (эрэгтэй 91, эмэгтэй 69) тамирчин өрсөлдсөнөөс, Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны ахмад Н.Эрдэнэбаатар, туслах дасгалжуулагч Х.Билгүүн дасгалжуулагчтай баг тамирчид 8 алт, 4 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр тэргүүлээ.

Тус тэмцээний шилдэг эмэгтэй тамирчнаар Алдар спорт хорооны тамирчин М.Сувд-Эрдэнэ шалгаргалаа. М.Сувд-Эрдэнэ нь Монголын бүх ард түмний спортын XIV наадамд 49 кг-ийн жинд түрүүлж байсан бол энэ удаагийн тэмцээний 46 кг-ийн жинд алтан медаль хүртэж, хошой аварга боллоо.

Эмэгтэй:

- 46 кг-ийн жинд М.Сувд-Эрдэнэ – алт
 - 49 кг-ийн жинд Б.Учрал – алт
 - 57 кг-ийн жинд С.Энхлэн – мөнгө
 - +62 кг-ийн жинд Д.Ангирмаа – алт
 - 53 кг-ийн жинд Т.Ганболор – алт
 - 62 кг-ийн жинд Г.Оюун-Эрдэнэ – мөнгө
- Эрэгтэй:
- 63 кг-ийн жинд Б.Соёл-Эрдэнэ – алт
 - 63 кг-ийн жинд Г.Энхбаяр – хүрэл
 - 58 кг-ийн жинд П.Дүүрэнжаргал – мөнгө
 - 68 кг-ийн жинд Д.Чинзориг – алт
 - 74 кг-ийн жинд Э.Буяншагай – алт
 - 74 кг-ийн жинд Б.Энх-Амгалан – хүрэл
 - 80 кг-ийн жинд Б.Баянбат – алт
 - +80 кг-ийн жинд П.Тэмүүжин – мөнгөн медаль тус тус хүртлээ.

ДЭД БАЙРТ ШАЛГАРЛАА



Монголын бүх ард түмний XV спортын их наадмын Чөлөөт бөхийн төрөлд Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны баг тамирчид багийн дүнгээр дэд байрт шалгарлаа.

Монголын бүх ард түмний спортын XV их наадмын чөлөөт бөхийн тэмцээн есдүгээр сарын 9-11-нд Баянгол дүүргийн спорт хорооны зааланд боллоо. Тэмцээнд 19 аймаг, 7 дүүргийн 198 тамирчин (эр 121, эм 79) олимпын жингийн ангилалд өрсөлдсөнөөс Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны МУГТ Г.Мандахнаран, Б.Одончимэг дасгалжуулагчтай баг тамирчид 2 алт 1 мөнгө, 4 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр дэд байрт шалгарлаа. Спартакиадын хамгийн гол үйл явдал нь 97 кг-ийн жинд Алдар спорт хорооны тамирчин ОУХМ О.Үйтүмэн 10 жилийн хугацаанд 3 дахь удаагаа түрүүлсэн нь онцлох үйл явдал боллоо. Үүнд:

Эмэгтэйчүүдийн:

- 50 кг-ийн жинд Б.Мөнхнар – хүрэл
- 57 кг-ийн жинд Б.Отгонтуяа – хүрэл
- 76 кг-ийн жинд Б.Одончимэг – хүрэл

Эрэгтэйчүүдийн:

- 65 кг-ийн жинд Д.Төрбаяр – хүрэл
- 74 кг-ийн жинд Г.Ханбүргэд – мөнгө
- 97 кг-ийн жинд О.Үйтүмэн – алт
- 125 кг-ийн жинд Э.Батмагнай – алтан медаль тус тус хүртлээ.

ХӨДӨЛГӨӨНТ ЯВУУЛЫН АМБУЛАТОРИ ОРХОН АЙМАГТ...



Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яам хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт явуулын амбулаторийн "Урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлэг"-ийнхэн Зэвсэгт хүчний 186 дугаар ангид энэ сарын 7-ны өдөр ажиллаж, бие бүрэлдэхүүнийг үзлэг, оношилгоонд бүрэн хамрууллаа.

Хошууч Ц.Ганбилэгээр ахлуулсан хөдөлгөөнт явуулын хоёрдугаар бүлгийнхэн бие бүрэлдэхүүнд нарийн мэргэжлийн 8 төрлийн тусламж үйлчилгээ, лабораторийн 8 төрлийн шинжилгээ, зүрхний бичлэг, цээжний рентген, ходоодны дурангийн шинжилгээг хийхийн зэрэгцээ тэдний гэр бүл, анги байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмадуудаа бүрэн хамруулж чадсан юм.

Ташрамд, Эрүүл мэндийн яамнаас 2022 оныг "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах" жил болгон зарласан бөгөөд хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд үнэ төлбөргүй хамруулах үйл ажиллагаанд Цэргийн төв эмнэлгийнхэн манлайлан оролцож, өнгөрсөн 5 дугаар сарын 1-ний өдрөөс орон даяар тойрон ажиллаж байна.